



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 11 дугаар сарын 21

№ 01/82

Мандалговь хот

Г Зөрчил арилгуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээ, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 203 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9 дэх заалт, аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Говь-Угтаал сумын сум дундын Эрүүл мэндийн төвийн 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийх явцад батлагдсан жишиг хэмжээг мөрдөөгүй нийт 5,706,050.00 / таван сая долоон зуун зургаан мянга тавин/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Сувилагч нарын баярт зориулан бичлэг хийлгэхэд төсвөөс 220,000.00 төгрөг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 9 -ны өдрийн 47 тоот тогтоолын 5-д /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/ заасныг тус тус зөрчсөн,

2. Нормын хувцас авах, ажилчдын хүүхдийн бэлэг бэлтгэх ажлаар 3 ажилтныг Улаанбаатар хотод томилолтоор ажиллуулж 126,000.00 төгрөгийн төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай Сангийн сайдын 2014 оны 6 дүгээр сарын 3 -ны өдрийн 122 тоот тушаалын 3-т /албан тушаалын болон албан ажлын автомашины хэрэглээний зардлыг багасгах, гадаад дотоод албан томилолтын зардлыг бууруулах, хурал сургалт, зөвөлгөөний давтамжийг багасган цахим хэлбэрээр зохион байгуулах/ заасныг тус тус зөрчсөн,

3. Ажилтныг томилогдсон сараас нь эхлэн 165,188.00 төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон.

Энэ нь Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тоот тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдад үр чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 5-д /ажилтанд олгож байгаа үр чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна/ заасныг зөрчсөн.

4. Төрийн үйлчилгээний албан тушаалд үндэслэл буруу шийдвэрээр улирлын цалингийн 70 хувиар 1,387,579.00 төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 40.4-т /Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэхэтгээд дараах арга

хэмжээг авна/ 40.4.2-т /хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох/ заасныг тус тус зөрчсөн.

5. Хүнсний материалыг батлагдсан жишиг нормыг мөрдөлгүй 3,807,283.00 төгрөгийн хяналтгүй зарцуулсан.

Энэ нь /Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаал/-ыг мөрдөөгүй тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/, 4.1.7-т /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дээрх зөрчлүүдийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх, цаашид холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Говь-Угтаал сумын сум дундын Эрүүл мэндийн төвийн дарга Г.Энхдэлгэр, нягтлан бодогч Б.Батцэнгэл нарт хариуцуулав.



## АЛБАН ШААРДЛАГЫГ

## ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА  
НЯГТЛАН БОДОГЧ

Г.ЭНХДЭЛГЭР  
Б.БАТЦЭНГЭЛ

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/